

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг нэмсүгэй:

1/2.2 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:

“14.Өсвөр насны хүн холбогдсон гэмт хэрэг, өсвөр насны хүнд холбогдуулан авах энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, өсвөр насны хүнийг энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасны дагуу баривчлах асуудлыг Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.”

2/2.2 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:

“Энэ хуулийн 2.2 дугаар зүйлийн 14-т заасан хэргийг энэ хуульд заасан шүүхийн харьяалал харгалзахгүйгээр Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.”

3/2.2 дугаар зүйлийн 16 дахь хэсэг:

“Энэ хуулийн 18.4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахаар байвал тусгаарлахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн газрын шүүх шийдвэрлэнэ.”

4/2.2 дугаар зүйлийн 17 дахь хэсэг:

“Энэ хуулийн 2.2 дугаар зүйлийн 14-т зааснаас бусад хэргийн шүүхийн харьяаллыг хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлын үүднээс гаргасан прокурорын саналыг үндэслэн Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоож болно.”

5/14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.7 дахь хэсэг:

“1.7.өсвөр насны яллагдагч, шүүгдэгч бол энэ хуулийн 14¹-д заасан баталгаа.”

6/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байлгах батлан даалт гаргах

1.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хууль ёсны төлөөлөгч болон бусад байнга оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчийн үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэн этгээд хяналтад байнга байлгах, тэднийг гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдохоос урьдчилан сэргийлэх, шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт ирүүлж байхыг хариуцаж, бичгээр батлан даалт гаргана.

2.Хэд хэдэн хүн батлан даалт гаргаж болно.

3.Уг таслан сэргийлэх арга хэмжээг өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад итгэмжлэгдсэн этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр авна.

4.Шүүх, прокурор, мөрдөгч өсвөр насны яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээг зөрчвөл таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг тайлбарлана.

5.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийг хяналтад байнга байлгах үүрэг хүлээсэн хүн хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл ногдуулна.”

7/18.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Мэдүүлэг авах ажиллагаа дууссаны дараа сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, сэтгэл зүйч нь мөрдөгчийн зөвшөөрлөөр насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчаас асуулт асууж болно.”

8/18.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Хойшлуулашгүйгээс бусад тохиолдолд өсвөр насны хүнийг сургууль дээр нь баривчлахыг хориглоно.”

9/25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

“Бага насны хүүхдээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч болон сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн сэтгэл зүйчийг заавал оролцуулах бөгөөд мэдүүлгийг хүүхдийн тусгай өрөөнд авч дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулна.”

10/29.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“10.Өсвөр насны яллагдагчийн үйлдсэн хэд хэдэн эрүүгийн хэргийг нэгтгэнэ.”

11/33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалт:

“1.4.өсвөр насны яллагдагчийн үйлдсэн хэргүүдийг нэгтгэх үндэслэл илэрсэн.”

12/35.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“Шаардлагатай тохиолдолд бага насны хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулахгүйгээр мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн мэдүүлгийн дуу, дүрсний бичлэгийг шинжлэн судална.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж, 14.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “үйлдсэн бол” гэсний дараа “энэ хуульд заасан өөр таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд” гэж, 18.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрвөл” гэсний дараа “энэ талаар болон тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараах сэтгэл санааны байдал, гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан талаар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах, шаардлагатай тохиолдолд сурган хүмүүжүүлэгчийг байлцуулах, сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйн байдалд эргэлзээ төрвөл мэдүүлэг авах ажиллагаанд сэтгэл зүйчийг оролцуулна.”

2/18.2 дугаар зүйл:

“18.2 дугаар зүйл.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага

1.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангана.

2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана.

4.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг хангаж ажиллана.

3/25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“Арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, сурган хүмүүжүүлэгч, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.”

4/35.15 дугаар зүйл:

“35.15 дугаар зүйл.Арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогч, шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох

1.Шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогч, шүүгдэгчээс мэдүүлэг авахад түүний оюун санааны байдал, учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх нөхцөл байдлыг улсын яллагч, өмгөөлөгч нь шалгана.

2.Шүүх улсын яллагч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогч, шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох үед түүний хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, сэтгэл зүйчийг оролцуулж болно.”

4 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “харгалзана.” гэснийг “харгалзан хувийн мэдээллийг нууцална.” гэж, 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.” гэснийг “өмгөөлөгчид нь даруй мэдэгдэнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулга бүхий 2.1-2.9 дахь заалт тус тус нэмсүгэй:

8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-2.9 дэх заалт:

“2.1. өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2. нийгэмд тустай ажил хийлгүүлэх;

2.3. нийгэмд чиглэсэн сайн дурын ажиллагаанд хамруулах;

2.4. хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.5. хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.6. шөнийн цагаар гэртээ байхыг даалгах

2.7. өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:”

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалтын “шийдвэрлэх” гэсний дараа “, бүрэлдэхүүнийг батлах” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсгийн “учирсан нь тогтоогдсон,” гэсний дараа “гэрлэгчид бие биенээсээ тусдаа амьдраад таван жил болсон ба гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, эсхүл бага насны хүүхэдгүй бөгөөд гэрлэгчид гэрлэлт цуцлуулах асуудлаар харилцан зөвшөөрсөн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.3 дахь заалт, Арван хоёрдугаар бүлэг, 133 дугаар зүйлийн 133.1.2-133.1.5 дахь хэсэг, 135 дугаар зүйлийн 135.2.1-135.2.2, 135.2.7-135.12 дахь хэсэг, 137-146 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “учирсан нь тогтоогдсон,” гэсний дараа “гэрлэгчид бие биенээсээ тусдаа амьдраад таван жил болсон ба гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, эсхүл бага насны хүүхэдгүй бөгөөд гэрлэгчид гэрлэлт цуцлуулах асуудлаар харилцан зөвшөөрсөн” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “тэжээн тэтгэх,” гэсний дараа “тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах уулзалт тогтоох,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд доор дурдсан агуулга бүхий 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг нэмсүгэй:

“9.4.Гэр бүлийн хэргийг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч явуулах бөгөөд энэ хуулийн 9.1, 9.2-т заасан шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байх тусгай шаардлага тавигдана.”

2 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “тэтгэмж,” гэсний дараа “хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах уулзалт тогтоох,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд” гэснийг “гэр бүлийн хэрэгт” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “Гэр бүлийн холбогдолтой маргааныг” гэснийг “Гэр бүлийн хэргийг” гэж, мөн зүйлийн 32.1 дэх хэсгийн “гэр бүлийн холбогдолтой маргаанд” гэснийг “гэр бүлийн хэрэгт” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан, Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасгай:

1/Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүхийн онцлог, зориулалтын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих газрын асуудлыг 2026 оноос өмнө шийдвэрлэх арга хэмжээг авах;

2/Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүхийн онцлогт нийцсэн зориулалтын шаардлага хангасан шүүхийн байр шинээр барихад шаардагдах зардлыг 2026 оны төсөвт суулгаж, санхүүжүүлэх;

3/Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн зардалыг 2026 оны төсөвт суулгаж, санхүүжүүлэх.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Шүүхийн ерөнхий зөвлөл /Н.Мөнгөнцэцэг/-т зөвлөсүгэй:

1/Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх болон тус шүүхийн харьяалах нутаг дэвсгэрийн бус бусад анхан шатны шүүхэд ажиллах гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч, эвлэрүүлэн зуучлагчийн хорооны гишүүн эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулж, томилох, сургах;

2/Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрийн бус бусад анхан шатны шүүхэд гэр бүл, хүүхдийн хэргийг шийдвэрлэх дагнасан шүүгчийг томилох;

3/Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх болон тус шүүхийн харьяалах нутаг дэвсгэрийн бус бусад анхан шатны шүүхэд ажиллах дагнасан шүүгчдийг шинээр батлагдсан хууль тогтоомж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургах;

4/Анхан шатны шүүх бүрд эвлэрүүлэн зуучлалын шүүгчийг томилох, сургах.

3.Өсвөр насны хүнд авагдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажлыг хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /Б.Нандинболор/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг